



МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/397

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-ын дүрмийн 22 дугаар зүйлийн “а” заалт, “Төмөр замын техник ашиглалтын журам”-ын 17.3.13 дугаар заалтыг үндэслэн галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагаанд тавих хяналтын үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор ТУШААХ нь:

1. “Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагаанд хяналт тавих “Хяналтын цэг”-ийн заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү зааврын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын албаны дарга (М.Цогт), Тээвэр зохион байгуулалтын албаны дарга (Ц.Ариунболд), Вагоны аж ахуйн албаны дарга (Л.Болд), Зүтгүүрийн аж ахуйн албаны дарга (Гук.Н.А), Замын аж ахуйн албаны дарга (Ю.Нямжаргал), Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын албаны дарга (Ц.Ариунбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Улаанбаатар төмөр замын хэрэг эрхлэх газрын даргын 2009 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/106 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



ХЭРЛЭН

1601242222

“УБТЗ” ХНН-ийн даргын оны дүгээр
сарын -ны өдрийн дугаар
тушаалын хавсралт



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИХ “ХЯНАЛТЫН ЦЭГ”-ИЙН ЗААВАР

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү заавраар өртөө, зөрлөг, хамгаалалттай гарам, гүүрээр өнгөрч байгаа галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих “Хяналтын цэг”-ийн үйл ажиллагаа болон “Хяналтын цэг”-т үүрэг гүйцэтгэгч ажлын чиг, үүргийг зохицуулна.


1.2. “Хяналтыг цэг”-т газар дээр нь очиж сургалт явуулах ажилтныг авто машин, сургалтын техник хэрэгслээр хангах ажлыг тулгуур өртөөд хариуцна.

Хоёр. Хяналтын цэгийг зохион байгуулах

2.1. Өнгөрч байгаа галт тэргэнд байнгын хяналт тавьж илэрсэн үл тохирлыг таслан зогсоож, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэгтэй ажилтнууд ажиллаж байгаа өртөө, зөрлөг (техник захирамжийн актаар өртөөний ажилтан галт тэргийг угтан авч үдэн гаргадаг)-т, хамгаалалттай гарам, гүүрийн тухайн ажилтны галт тэргийг угтан авч, үдэн гаргах зориулалт бүхий “Техник захирамжийн акт” болон “Орон нутгийн заавар”-т заагдсан газрыг “Хяналтын цэг” гэнэ.

2.2. Хяналтын цэг дээр шар өнгийн анхааруулах тэмдэг бүхий цагаан / хоёр тал нь ижил / өнгөтэй “ХЯНАЛТЫН ЦЭГ” самбарыг уг цэгт үүрэг гүйцэтгэгчийн ажлын байрны ойролцоо, уг байрны талаас эхний замын тэнхлэгээс 3100 мм-ээс багагүй зайд байрлуулна.

2.3. “ХЯНАЛТЫН ЦЭГ”-ийн самбарын бүрэн бүтэн байдал болон түүний засвар, үйлчилгээг өртөөд бүрэн хариуцаж ажиллана.



Самбарыг 3-4 мм
зузаантай хуудас
төмрөөр, шонг 80x80
мм-ийн хөндлөн
огтлолтой модоор буюу
80 мм-ийн голчтой
төмөр хоолойгоор хийж,
газарт суулгана.

2.4. Шөнийн цагт буюу үзэгдэх орчин муу нөхцөлд галт тэрэгний бүрэлдэхүүний техникийн болон ачааны байдлын үзэгдэлтийг сайн байлгахын тулд паркийн гэрэлтүүлэг болон тусгай зориулалтын тусгал сайтай зөөврийн буюу суурин гэрэлтүүлгээр тоноглоно.

2.5. “Хяналтын цэг”-т үүрэг гүйцэтгэж байгаа ажилтныг гар дохионы хэрэгслэлээр хангасан байвал зохино.

2.6. “Хяналтын цэг”-т үүрэг гүйцэтгэх ажилтны ажлын байранд галт тэрэгний байдалд хяналт тавьж өнгөрүүлэх гарын авлага, санамж болох зурагт самбар, үзүүлэн байрлуулна.

Гурав. “Хяналтын цэг”-ийн үйл ажиллагаа

3.1. “Хяналтын цэг” болгон зохион байгуулсан өртөө, зөрлөгийн жижүүр (туслах жижүүр), гармын жижүүр, гүүрийн харуул нь “Төмөр замын техник ашиглалтын журам”-ын 17.3.13-ын дагуу доорхи хяналтыг (харагдах байдал, дуу чимээ, үнэр, халалт зэргээр үндэслэн) тавьж, үл тохирол илэрсэн тохиолдолд галт тэргийг нэн даруй зогсоох арга хэмжээг авах ба галт тэрэгний хөдөлгөөний зохицуулагчид мэдэгдэн, үл тохирлыг арилгах шуурхай арга хэмжээ авна. Үүнд:

- Хос дугуй эргэхгүй, чирэгдэж явах
- Аяллын үед хос дугуй эргэж байсан ч шахавч дугуй хоорондоо их хэмжээний утаа, оч гарч, чихарсан дуу чимээ гарах;
- Хос дугуйн өнхрөх гадаргад чирэг, шаваас гарснаас дугуй зам төмөрт хүчтэй цохиж байх;
- Гүүшингээс гал гарсан, бага боловч утаа гарах;
- Тэргэнцэр хүчтэй донсолсон, дугуй жигд эргэж чадахгүй байх, гүүшингээс чихарсан дуу гарах;
- Бүх төрлийн вагоны хаалга, нээлхий онгойж, байрнаас хөдөлсөн овроос гарсан;
- Гүүшингийн үзлэгийн болон бэхэлгээний таг байхгүй;
- Тоормосын хөшүүргийн татуургууд унжсан, унаж хамгаалах гогцоон дээрээ байгаа, эсвэл чирэгдсэн;
- Зөөлөн холбоос вагонуудын хооронд унжиж явах;
- Авто угсрааны салгах хөшүүрэг байрнаасаа хөдөлсөн, өргөгчийн гололцор унжсан;
- Цистерн вагоны тогооны бүс тасарч чирэгдсэн;
- Вагоны тэвш явах ангид хавирсан;
- Зорчигчийн вагоны зай хураагуурын хайрцаг онгорхой байх болон тэнд гал гарч байгаа нь үзэгдэх;
- Зорчигчийн вагоны редуктор кардан дамжуулгын кардан тасарч хамгаалах төхөөрөмж дээр унасан;
- Зорчигчийн вагоны аль нэг хаалга онгорхой явах;
- Хөдлөх бүрэлдэхүүнд ямар нэгэн зүйл чирэгдэж явах;
- Задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачсан ачааны бэхэлгээ тасарсан, шон хугарсан, ачаа байрнаас хөдөлсөн, хазайж овор хэтэрсэн;
- Вагоны аль нэг хэсгээр ачаа гоожиж явах;
- Ачаа унасан, хулгайлагдсан, гоожсон шинж тэмдэгтэй байх;
- Ачаа буюу вагоны эд ангид гал гарсан, утаа уугисан.

Дээрх байдлыг илрүүлэн галт тэргийг зогсоосны дараа галт тэрэгний хөдөлгөөний зохицуулагчид мэдэгдэх ба үл тохирлыг арилгах шуурхай арга хэмжээ авна.

3.2. Зүтгүүрийн бригад “Хяналтын цэг”-т ойртож ирэхдээ сэрэмжлүүлэх дохио өгөх ба “ХЯНАЛТЫН ЦЭГ”-ийн дэргэд галт тэргийг угтаж байгаа ажилтан, зүтгүүрийн машинч, туслах машинч нар гараа дээш өргөж дохиог харилцан давталцана.

Энэ нь галт тэрэгний байдалд хяналтын цэгээс хяналт тавьж байгааг батлах бөгөөд энэ үеэс эхлэн зүтгүүрийн машинч (туслах машинч) хяналтын цэг байрлаж байгаа талын цонхоо онгойлгож, галт тэргэнд хяналт тавьж байгаа ажилтан зогсоох дохио өгсөн тохиолдолд зүтгүүрийн машинч галт тэргийг яаралтай зогсоох үүрэгтэй.

Хэрэв зүтгүүрийн бригад зогсоох дохиог ямар нэг байдлаар хараагүй, галт тэргийг зогсоох арга хэмжээ аваагүй бол “Хяналтын цэг”-ийн ажилтан нь галт тэргийг зогсоох бүхий л төрлийн (радио станцаар мэдэгдэх) арга хэмжээг авах ёстой.

3.3. Хөдөлгөөнтэй холбоотой албад, нэгжүүдийн ажилтнууд нь албан үүргээ гүйцэтгэж байхдаа галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагаанд дээрхтэй нэгэн адил хяналт тавина.

3.4. “Төмөр замын техник ашиглалтын журам”-ын 17.3.13-т заагдсан албан тушаалтнуудын “Галт тэргийг угтан авах, үдэж өнгөрүүлэх ажиллагаа”-г ажлын заавар, технологийн горимд тэдний шууд удирдах албан тушаалтан (Өртөө, Депо, Замын анги, Дохиолол холбооны анги, Цэрэгжүүлсэн хамгаалах ангийн дарга нар) тодорхой тусгах үүрэгтэй.

Дөрөв. “Хяналтын цэг”-ийн ажлыг шалган, зааварчлах

4.1. “Хяналтын цэг”-т албан үүрэг гүйцэтгэдэг албан тушаалтнуудад галт тэрэг угтан авч, үдэж өнгөрүүлэх үед тухайн галт тэрэгний бүрэлдэхүүнд байгаа хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд хэрхэн хяналт тавих талаар сургалт зааварчилгааг жилийн **1; 3 дугаар улиралд** тулгуур өртөөдийн ачаа тээвэр эрхэлсэн орлогч дарга, Техник үйлчилгээний газрын дарга **биечлэн** очиж сургалт явуулж зааварчилна. **2; 4 дүгээр улиралд** тулгуур өртөөдийн ачаа тээвэр эрхэлсэн орлогч дарга, Вагон ашиглалтын депогийн хэсэг хариуцсан орлогч дарга нар зайнаас **цахим хэлбэрээр** зохион байгуулна.

Өртөөдийн ачаа, тээвэр эрхэлсэн орлогч дарга, ТҮГ-ын дарга нар сургалт явуулж, зааварчилгаа өгөх өртөөдийн жагсаалт

Хүснэгт №1

№	Өртөөдийн ачаа тээвэр эрхэлсэн орлогч дарга	Вагон ашиглалтын депогийн орлогч дарга нар	ТҮГ-ын дарга нар	Сургалт явуулж, зааварчлан, хяналт тавих өртөө, зөрлөг
1	Сүхбаатар	Хойд хэсэг хариуцсан орлогч дарга	Сүхбаатар ТҮГ	Хойд
2				Сүхбаатар
3			Ерөө ТҮГ	Дулаан
4				Ерөө
5	Орхон			
6	Дархан		Дархан ТҮГ	Энхтал,
7				Дархан-1
8				Дархан-2
9				Шарын гол
10	Салхит ТҮГ		Цайдам	
11			Салхит	
12			Хөтөл	
13	Эрдэнэт		Эрдэнэт ТҮГ	Эрдэнэт
14				Улаан толгой
15				Хангал
16				Орхон туул
17				Бэлэн далай

18	Зүүнхараа		Зүүнхараа ТҮГ	Баруун хараа
19				Эрхэт
20				Зүүнхараа
21				Үнэгт
22				Түнх
23	Толгойт	Төвийн хэсэг хариуцсан орлогч дарга	Толгойт ТҮГ	Шатанга
24				Мандал
25				Ногоон толгой
26				Аршаант
27				Давааны
28	Эмээлт			
29	Толгойт			
30	Улаанбаатар		Улаанбаатар ТҮГ	Амгалан
31				Туул
32				Хонхор
33				Бумбат
34				Хоолт
35			Баян	
36			Хайрхан	
37			Багахангай ТҮГ	Цагаан хяр
38				Чулуут
39				Хангай
40	Багахангай			
41	Мааньт			
42	Агуйт			
43	Багануур	Багануур ТҮГ	Булагтай	
44			Багануур	
45	Чойр	Чойр ТҮГ	Наран-Элгэн	
46			Оорцог энгэр	
47			Лүн	
48			Чойр	
49			Шивээ овоо	
50		Шивээ говь		
51		Айраг ТҮГ	Өлзийт	
52			Цомог	
53			Олон-Овоо	
54			Айраг	
55	Бор өндөр			
56	Сайншанд	Сайншанд ТҮГ	Алтганы гол	
57			Улхын-Овоо	
58			Сайншанд	
59			Түшлэг	
60			Өргөн	
61			Долоодын хөндий	
62			Зүүн баян	
63			Замын үүд	Замын үүд ТҮГ
64	Номт			
65	Цагаан хад			
66	Авгын гол			
67	Нартын хошуу			
68	Замын үүд-2			
69	Замын үүд-1			
70	Нарийн цэргийн өртөө			

4.2. “Хяналтын цэг” бүрт зааварчилгааны дэвтэр байх бөгөөд зааварчилгаа өгсөн ажилтан түүний хуулбар хувийг авч 6 сарын хугацаанд хадгална.

4.3. Тээвэр зохион байгуулалтын албаны ачаа тээврийн байцаагч, Вагоны аж

ахуйн албаны ГТХАБ хариуцсан хэсгийн байцаагч нар өөрийн хариуцсан хэсэглэл дэх харьяа “Хяналтын цэг”-үүдийн үйл ажиллагаанд улирал бүр шалгалт хийнэ.

4.4. “Хяналтын цэг”-т ажил үүрэг гүйцэтгэх ажилтан шинээр томилогдох тохиолдолд Хүснэгт №1-т заагдсан жагсаалтын дагуу тухайн хэсэглэл хариуцсан Техник үйлчилгээний газрын даргаас сургалт, зааварчилгааг авна.

4.5. Уг зааврын 4.1-р заалтын дагуу улирлын болон шинээр томилогдсон ажилтны сургалт зааварчилгааг цаг тухайд нь аваагүй ажилтнуудыг “Хяналтын цэг”-т ажиллуулахыг хориглоно.

4.6. Сургалт зааварчилгаанд цаг үеийн нөхцөл байдалд тохируулан шинээр нэвтэрсэн техник, технологи, техникийн нөхцөлийн талаар тусгасан байвал зохино.

Тав. Илэрсэн үл тохирол бүртгэж, судлах

5.1. “Хяналтын цэг”-т илэрсэн үл тохирлыг Вагоны аж ахуйн албаны диспетчер /ВД/ доорх хүснэгт бүхий дэвтэрт цаг алдахгүй бүртгэж, холбогдох албан тушаалтнуудад шуурхай мэдэгдэнэ.

Хүснэгт №2												
Дэд дугаар	Галт тэрэгний дугаар	Машинчийн нэр	Голын тоо	Үл тохирол илэрсэн хөдлөх бүрэлдэхүүний дугаар	Үл тохирол илэрсэн хөдлөх бүрэлдэхүүний төрөл	Гарсан үл тохирол	Галт тэрэгний диспетчерт мэдээлэгдсэн цаг	Шуурхай авсан арга хэмжээ	Галт тэрэг зогссон хугацаа	Үл тохиролыг бүртгэсэн ажилтаны нэр	Танилцсан албан тушаалтан	Буруут байгууллагаас өгсөн хариу

“Хяналтын цэг” дээр галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагаатай холбоотой үл тохирол илэрсэн тохиолдол бүрийг хяналтын цэгт ажиллаж байгаа ажилтан нэн даруй галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч эсвэл өөрийн албаны диспетчерт мэдэгдэж, “Хяналтын цэгийн бүртгэл” гэсэн дэвтэрт бүртгэн, дараа нь өөрийн удирдлагадаа мэдээлэх үүрэгтэй.

5.2. Үл тохиролтой холбоотой алба, аж ахуйн нэгжүүд судлан, авсан хариу арга хэмжээ, зохион байгуулсан ажлын талаар 3 хоногийн дотор Тээврийн хяналтын албанд илтгэж, “Хяналтын цэгийн бүртгэл” дэвтэрт бичлэг хийнэ.

5.3. “Хяналтын цэг”-т үүрэг гүйцэтгэж байхдаа албан үүргээ сайн биелүүлж галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, гарч болзошгүй осол, сүйрлээс сэргийлсэн ажилтанг тогтоосон журмын дагуу шагнаж урамшуулахын зэрэгцээ галт тэргэнд хяналт тавих хяналтыг журмын дагуу хийгээгүй, гэмтэл, үл тохирлыг цаг тухайд нь илрүүлж шаардлагатай арга хэмжээг аваагүйгээс дутагдал, гологдолд хүргэсэн ажилтанд “Төмөр замын тээврийн тухай” хууль болон бусад журам, зааврын дагуу арга хэмжээ ноогдуулна.

5.4. Өртөө, зөрлөг хоорондын замд энэ “заавар”-ын дагуу галт тэргийг зогссон үед техникийн үл тохиролгүй бол бусдаар тооцож тайлбар хийнэ.